



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 87734

Улаанбаатар хот

С.Батсүхэд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.3, 48.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.4, 10.6, 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Суманхөхийн Батсүх албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийг зөрчсөн нь Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 2/691 дугаартай албан бичиг, өөрийн гаргасан тайлбар, холбогдох бусад нотлох баримтаар тогтоогдсон тул түүнд 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлагыг хангаж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Батсүхэд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Г.Булгантамир/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

- 142304819